



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 11507

Арвайхээр сум

### Г Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 57,56км авто замд ашиглагдаж байгаа түр замыг орон нутгийн хэрэгцээнд байнгын ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад авах журам”-ыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс (Б.Мөнхбат)-т даалгасугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар  
сарын 24-ны өдрийн 11:00 дугаар  
захирамжийн хавсралт

АВТО ЗАМЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ  
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Б.Мөнхбат (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:  
Ц.Алтан-Эрдэнэ (аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч)

Ц.Нэргүй (Архивын тасгийн дарга, Архив, албан хөтлөлтийн хяналтын улсын байцаагч)

Б.Батбаяр (ӨВ АЗЗА ТӨХК-ийн ерөнхий инженер)

Гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Б.Цогтбаатар (аймгийн Засаг даргын Тамгын газрын Авто замын хяналтын улсын байцаагч)

-оОо-